

ХУУЛЬ САХИУЛАХ УДИРДЛАГА
ХСИС-ийн Удирдлагын сургуулийн
ОБУПБ-ийн профессор, онцгой байдлын,

хурандаа Г. Буянтогтох

ХИМИЙН ХОРТ БОДИСЫН ХУУЛЬ БУС ХЭРЭГЛЭЭНИЙ
УЛМААС ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧИНД НӨЛӨӨЛЖ БУЙ ХОР НӨЛӨӨ

АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭ

Манай орны Төв, Сэлэнгэ, Баянхонгор, Өмнөговь аймагт химийн хорт болон аюултай бодисыг хууль бусаар ашигласны улмаас технологийн холбогдолтой осол, хордлого, бохирдол удаа дараа гарч хүрээлэн буй орчин, хүн, мал амьтны удмын санд нөлөөлж ихээхэн хэмжээний хохирол учруулж байсан бодит жишээ баримт олон бий.

Энэ ажлын хүрээнд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, БХЯ, БОНХЯ, ЭМЯ, ҮХЯ, ОБЕГ, ЦЕГ, ТЕГ, ХХТХ-ийн төлөөлөлөөс бүрдсэн ажлын хэсэг гарч хяналт, шалгалтыг удаа дараа явуулж бохирдсон хэсэг, бүсийг тогтоох, тоног төхөөрөмжийг хураах, химийн хорт бодисын хууль бус хэрэглээ болон түгээмэл тархаж байсан хар технологийг бүрэн зогсоож, улмаар газрын хэвлийн эвдэрсэн хэсэгт техникийн нөхөн сэргээлтийг явуулж, иргэд, мал амьтны эрүүл, аюулгүй амьдрах нөхцлийг бүрдүүлэн ажилласаар ирсэн.

Өнөөгийн байдлаар дэлхийд 10 сая гаруй нэр төрлийн химийн бодис бүртгэгдсэний 70 мянга орчим нь бидний ахуй амьдралд өдөр тутам ашиглагдаж байгаагаас 10 мянга гаруй нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд ямар нэг байдлаар сөрөг нөлөө үзүүлж, эдгээрээс 200 гаруй нь хорт хавдар, өмөн үү өвчний эх үүсвэр болдог болох нь батлагдаад байна.

Манай улсын хэмжээнд худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ, эрдэм шинжилгээ, судалгааны салбарын үйл ажиллагаанд ашиглах зориулалтаар хортой болон тэсрэмтгий, шатамхай, исэлдүүлэгч, идэмхий гэх мэт ангилалаар химийн хорт бодисын тусгай зөвшөөрөл авсан 300 гаруй байгууллага, аж ахуйн нэгж 450 нэр төрлийн химийн бодисыг хилийн 7 боомтоор оруулж ашиглахаар 2011 оны нэгдсэн тооллогод бүртгэгдсэнээс 2012 онд тусгай зөвшөөрлөөр 281 аж ахуйн нэгж байгууллага 600 аад нэр төрлийн хорт бодис импортлогдож, тэдгээрээс агаарт 100, ус болоод хөрсөнд 1000 гаруй нэр төрлийн химийн бодис ялгаран хаягддаг гэсэн тоо байна.

Дээр дурдсан химийн хорт болон аюултай бодисын зохисгүй хэрэглээнээс болж байгаль орчин их хэмжээгээр бохирдож улмаар олон мянган хүн, мал хордлоогэсэн асуудал гамшгийн хэмжээнд хүрсэн он жилүүд саяхан байсан ба цаашид ч үүсэх хандлагатай.

Монгол Улс төлөвлөгөөт эдийн засгийн нийгмээс зах зээлийн харилцаанд шилжих шилжилтийн үе буюу 1990-ээд оны эхэн үед төр, засгаас “Алт хөтөлбөр”-ийг санаачлан боловсруулж хэрэгжүүлсэнтэй холбоотой мал хувьчлагдан үнэгүйдэж эзэнгүйдэн олон арван залуус төв, суурин газрыг бараадан ганзгын наймаа ид цэцэглэж байх үеэс БНХАУ-д 1950-д оноос эхэлж ашиглахаар хувь хүмүүсийн санаачлан үйлдвэрлэсэн тоног төхөөрөмж, технологийг хилийн боомт, гаалиар оруулж ашиглан алтны үндсэн ордын хүдрийг тээрэмдэж нунтаглан дэлхийн зарим оронд Тухайбал: (ӨАБНУ, БНХАУ, Чили) гэх мэт хувиараа алт олборлогчдын нэгэн адил мөнгөн усаар амалгам, циант натрийг ашиглан уусгалтын аргаар зарим аймаг, сумдын нутаг дэвсгэрт гадны иргэдтэй хамтран алт олборлож эхэлсэн түүхтэй.

Үүний улмаас улсын хэмжээнд химийн хорт болон аюултай бодисын холбогдолтой осол, бохирдол, хордлого дээрхи он жилүүдэд 12 аймгийн 30 гаруй сумын нутаг дэвсгэрт үүссэнийг Монгол Улсын засгийн газар, БОАЖЯ-ны Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын үндэсний зөвлөлийн Ажлын алба, шинжээчдийн багаас гаргасан зөвлөмжийн дагуу холбогдох мэргэжлийн байгууллагууд ажиллан ид өрнөж байсан ажиллагааг бүрэн зогсоосон юм.

Хэдийгээр үйл ажиллагааг тухайн үед зогсоосон гэж үздэг боловч өнөөгийн нийгмийн хэвийн үзэгдэл болсон ажилгүйдэл, өрхийн орлого, эдийн засгийн хэт шунхайрал, багахан хугацаанд хөнгөн аргаар их орлого олж баяжих гэсэн тэмүүлэл, зорилгоор химийн хорт бодисын хууль бус хэрэглээг ашиглан улам нарийн техник, технологийг бий болгож хүн амын эрүүл мэнд, мал амьтан, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдэх болж байгаад бид дүгнэлт хийх цаг хугацаа болжээ.

Өнөөгийн тавигдаж байгаа зорилго бол химийн хорт болон аюултай бодисын зохисгүй хэрэглээнээс үүссэн хордолт, бохирдолтын голомтод аврах, хор уршгийг арилгахад ажиллах бүрэлдэхүүний аюулгүй байдал, хоргүйжүүлэх арга ажиллагааг боловсронгуй болгоход оршиж байна.

Химийн хорт бодисын зохисгүй хэрэглээ нь хүн ам, мал амьтны удмын сан, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь техник эдийн засаг, экологийн хувьд учруулах хор уршиг, хамрах хүрээ, өрнөх хугацаа ихтэй бөгөөд цаашид үзүүлэх хоёрдогч аюулын зэрэглэл, нөлөөлөл өндөр тул байгаль, цаг агаарын аюулт үзэгдэл болон технологийн холбогдолтой бусад гамшиг, ослоос онцлог ялгаатай.

Энэ төрлийн гамшиг осол нь ихэвчлэн нэр төрөл, шинж чанар тодорхой бус харъяалах эзэнгүй ашиглалт, хадгалалтын горим зөрчигдөн хаягдсан тэдгээртэй харьцаж буй ажилчдын санамсар болгоомжгүй, буруутай үйлдэл, хорлон сүйтгэх зорилгоор гэмт халдлага үйлдэх, эдийн засгийн сонирхолын

хүрээнд хууль бус үйл ажиллагаа явуулсан мөн тоног төхөөрөмжийн горим алдагдах, элэгдэл хорогдол бий болох, цаг улиралын засвар үйлчилгээ хийгдээгүй зэрэг хүчин зүйлүүдээс тохиолддог бөгөөд үүний уршгаар хорт бодис дангаар болон нэгдмэл байдлаар алдагдаж химийн хорт бодисын ослын цагийн байдлыг үүсгэдэг байна.

Иймд болзошгүй химийн хорт болон аюултай бодисын цагийн байдал, эрсдэлийг үнэлэхдээ хүн амд үзүүлэх аюул, тэдгээрийн эмзэг байдал, осол болох магадлал, түүнтэй тэмцэх томилгоот хүч, хэрэгслийн чадавхи зэрэг хүчин зүйлсийг сайтар тодорхойлох нь чухал асуудал юм.

Аливаа гамшгийн эрсдэлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх, аюулыг бууруулах арга хэмжээг төлөвлөх нь Монгол Улс төдийгүй дэлхий нийтээр анхаарлаа хандуулж буй тулгамдсан асуудлуудаас томоохон байр суурийг эзлэх болж, бид бодлогын асуудлыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүднээс Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын үндсэн чиглэл, Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр¹ /2011- 2015, 2015-2020 он/-ийг УИХ-ын 2011 оны 22 дугаар тогтоолоор батлуулсан.

Гамшгаас хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулын зэргийг бууруулах үйл ажиллагааг Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Улсын нөөцийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулдаг боловч одоо үйлчилж байгаа энд дурьдсан хууль эрх зүйн баримт бичгүүдийн заалтуудын агуулга, томъёололыг сайжруулах, амьдрал үйл ажиллагаанд нийцүүлэн оновчтой улам боловсронгуй болгон эрсдэл, эмзэг байдлыг бууруулах, иргэдийг аюулгүй амьдрах арга ухаанд сургах, ажил амьдралын хэв шинжийг өөрчлөх, сургалт сурталчилгаа явуулах тэдгээрийн амьдрах таатай орчин нөхцлийг бий болгох шаардлага урган гарч байгааг энд зориуд тэмдэглэх нь чухал юм.

Монгол Улс төдийгүй дэлхий нийтийн хандлага экологийн асуудлыг дээшлүүлж, эх оронч үзлийг төлөвшүүлэх замаар эх орон, унаган байгалиа хамгаалах асуудлыг хурцаар тавих болсон. Үүнтэй холбоотой ногоон химийг гол зорилгоо болгон харьцангуй хор багатай, байгаль орчинд ээлтэй түүхий эд, цэвэр технологийг ашиглан химийн хорт болон аюултай бодисын эрсдэлээс сэргийлэх ажлыг бүх нийтийн үүрэг хариуцлага болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хэдийгээр төр, захиргааны холбогдох мэргэжлийн байгууллагууд хяналт, шалгалтыг явуулж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг зохион байгуулсан ч агаар, хөрс, усанд алдагдсан химийн бодисын нөхцөл байдлыг сүүлийн 5 жилийн байдлаар улсын хэмжээнд 69 удаагийн тохиолдлоор гарсан осол, зөрчлийг ангилахад:

¹ Цахим эх сурвалж холбоос: <http://www.legal.info.mn/annex/details/3372?lawid=5909>

мөнгөн ус 48%
натрийн цианид 6%
үл мэдэгдэх 25%
амьсгал боогдуулагч 4%
аммиак, хлор 7%
түлшний асгаралт 3%-ийг тус тусыг эзлэж байна.

Мөн 12 аймгийн 34 сумдын нутаг дэвсгэрт 230 гаруй цэгт 128440 м² га талбайд 197 орчим мянган тонн химийн бодисын бохирдлоор бохирдож зарим тохиолдолд сумаараа хордлогод өртсөн гэх асуудал ч гарч байлаа.

Эдгээр үүссэн нөхцөл байдлын голомтод аврах, хор уршгийг арилгах арга хэмжээг төр, засгаас бодлогоор дэмжиж зохион байгуулсан ч авч хэрэгжүүлсэн ажлын талаар иргэдэд төдийлөн бодит мэдээ, мэдээлэл өгөөгүй, иргэдийн мэдлэг муу зэргээс улс төржих хэлбэрт орж олон улсын төрөлжсөн мэргэжлийн байгууллага ДЭМБ, Хүнс хөдөө аж ахуйн болон байгаль орчны байгууллагын мэргэжилтнүүд 2008, 2009 онд ирж судалгаа, шинжилгээнүүд хийгдэж байсан ба өнөөдрийг хүртэл уг ажлууд давтагдан хийгдэж бохирдол, хордлого байсаар байна.

Зөвхөн нэг аймгийн нэг суманд химийн хорт бодисыг хууль бус ажиллагаанд ашиглаж үйл ажиллагаа явуулсны улмаас үүссэн нөхцөл байдлын талаар авч үзвэл Төв аймгийн Борнуур суманд арав гаруй хүн Сүжигт ууланд амь насаа алдаж, 6 хүн уушигны хорт хавдар тусч, олон иргэн тэсрэх бодисыг буруу хэрэглэснээс нүд, гаргүй болон бэртэж гэмтэн эрүүл мэндээрээ хохирсон байна.

2013-2014 онд Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээс мөнгөн усны хордлого ихтэйгээрээ алдаршсан Төв аймгийн Борнуур, Жаргалант сумын иргэдээс тусгайлан хордлогын судалгаа авч үүнд Борнуур сумаас 81 нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд хамрагдсан байна.

Энэ судалгаагаар хүний үсэнд мөнгөн усны агууламжийг тодорхойлох шинжилгээг МХЕГ-ын нэгдсэн лабораторт, шээсэн дэх мөнгөн усны шинжилгээг Герман Улсын Мюнхен хотын их сургуулийн эмнэлгийн хүрээлэнд, цусан дахь мөнгөн усны агууламжийг Их Британи Улсын Боксоны цацраг хийн болон хүрээлэн буй орчны сөрөг нөлөөллийн төвийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны лабораторт тус тус шинжлэхэд Борнуурчуудын цус, үсэн дэх мөнгөн усны хэмжээ маш өндөр, яаралтай арга хэмжээ авах шатанд хүрсэн байсан нь тогтоогдсон байна.

Энэ мэтчилэн хүний буруутай үйл ажиллагаанаас экологид асар их хар ул мөр үлдээснээс үүдэн байгаль цаг уурын хэмнэл алдагдаж, гол ус ширгэх нь ихсэж байгаа ба цаашид байгалийн гамшгийн хор уршиг улам бүр нэмэгдэх хандлагатай болж байна. Байгаль цаг агаарын гамшгийн хор уршгийг амсаагүй хүн ард түмэн дэлхийд бараг үгүй болж байна, цаашдаа асар их хор уршигтай

гамшгууд үүсэх магадлал өндөр байна. Мөн үүнээс улбаалан үүсч болзошгүй сөрөг үр дагаварууд тухайлбал ургамлын ургаж эхлэх хугацаа оройтож хавар хуурайшин, экосистем доройтох улмаар цөлжих. бэлчээрийн мал аж ахуй улам эмзэг болох. цэвдгийн гэсэлтээр тэжээгдэх голын урсац багасах аюул нүүрлэхийг үгүйсгэхгүй.

Энэ нь өөрөө хүн байгалийн эргэх хүйн холбоо алдагдаж, хүний хүчин зүйлийн сөрөг нөлөө нь экологийн тэнцвэртэй байдлыг алдагдуулж, улмаар хүн төрөлхтөн сөнөх аюулыг бий болгож байна гэж хатуухан бөгөөд үнэнийг өгүүлэх цаг болсныг харуулж байна.

Өнгөрсөн хугацаанд дэлхийн экологид асар их хар ул мөр үлдээснээс үүдэн эх болсон байгаль дэлхийн ааш араншин өөрчлөгдөж, тэрчлэн Азийн зарим орон Филиппин, Тайланд, БНХАУ, Япон зэрэг улс болон хүн төрөлхтөнд тохиолдож байгаа байгалийн гамшгийн хор уршиг, давтамжийн тоо нэмэгдэж, нийгэмд үзүүлж байгаа экологи-эдийн засгийн хохирол хэдэн арван их наяд ам, доллараар хэмжигдэх болжээ.

Химийн бодисын холбогдолтой тулгамдаж буй асуудалыг дараах байдлаар тодорхойлж болохоор байна. Үүнд:

- Химийн хорт бодистой харьцагч нарын мэдлэг, дадлага туршлага төдийлэн шаардлага хангахгүй, эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ хийгдээгүй зөвшөөрөлгүй зарж борлуулдаг мөн химийн хорт бодисын холбогдолтой ослын нөхцөл байдлын үед бодит мэдээ мэдээллийг мэргэжлийн байгууллагад өгдөггүй;

- Химийн хорт бодисыг ачиж буулгах, шилжүүлэн ачих, хадгалах ашиглах орчин нь ихэвчлэн нийслэл хотод хүн ам олноор төвлөрсөн бүс, салхины дээд хэсэгт явагддаг;

- Төр, захиргааны болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд ашиглалт, хадгалалтын горим зөрчигдсөн нэр төрөл, шинж чанар тодорхой бус химийн хорт бодисын хуримтлал ихтэй, зориулалтын булшлах цэг байхгүй;

- Ахуйн хог хаягдалд агуулагдах хорт нэгдлүүд нь агаар, ус, хөрсөөр дамжин тархвал хүний биед удаан хугацаанд үл мэдэгдэх хэмжээгээр агуулагдан хуримтлагдсанаар хорт хавдар үүсгэх, генийн өөрчлөлт, ургийн гаж хөгжилтэй төрөлт нэмэгдэх магадлал өндөр байгаа зэргээр тодорхойлж байна. Үүний тулд дараах дүгнэлт саналыг дэвшүүлж байна.

1. Химийн хорт бодисын зохисгүй хэрэглээ, харьцагсдийн буруутай үйл ажиллагаанаас химийн ослын цагийн байдал үүсч бохирдолт, хордолтоос хүрээлэн буй орчин, хүн мал амьтны эрүүл мэндэд сөргөөр үзүүлэх нөлөөлөл буурахгүй байгаа нь улс орны тогтвортой хөгжил, экологийн сүйрэл цаашлаад байгаль, цаг агаарын аюулт үзэгдлийн тоо, давтамжийг нэмэгдүүлэх томоохон

хүчин зүйлүүдийн нэг болж байна. Иймд химийн хорт болон аюултай бодисийн хэрэглээг багасгаж, улмаар хүн болон байгаль орчинг бохирдуулах нөлөөлөлийг багасгах зорилгоор ногоон химид суурилсан цэвэршүүлэх, хаягдалгүй, цэвэр технологийг бүхий л үйл ажиллагаандаа нэвтрүүлэн эзэмшиж, боловсронгуй болгон хөгжүүлж, улмаар үргүй зардал, хог хаягдлыг бага үүсгэх;

2. Хүн амын төвлөрөл бий болсон ундны усны эх үүсвэрийн голомтод үйл ажиллагаа явуулж буй арьс шир, ноос, ноолуур боловсруулах үйлдвэрээс гарч буй хаягдлуудын байгаль орчинд үзүүлж байгаа хорт нөлөөллийг бууруулах;

3. Үйлдвэрүүдийн тунгаагдсан шавар, цахилгаан станцын үнс болон барилгын материалуудын үйлдвэрийн хаягдалд агуулагдах хүнд металл болон цацраг идэвхит нэгдлийн агууламжийг бууруулах технологи шийдлийг гаргаж өргөнөөр ашиглах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна гэж үзэж байна.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн
821 дүгээр дамжааны сонсогч,
ахмад Г. Энхболд*

ШШГБ-ЫН АЛБАН ХААГЧДЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ ЗАРИМ АСУУДАЛ

XX зууны Монгол Улсын анхны төрийн байгууллагуудын нэг гяндан салаа, одоогийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь /цаашид ШШГБ гэх/ түүхт 93 жилийнхээ хугацаанд төрийн өмнө хуулиар хүлээсэн амаргүй бөгөөд нэр төртэй үүргээ амжилттай биелүүлсээр ирсэн бөгөөд тухайн үеийн нийгэм, улс төр, эдийн засгийн тогтолцоо, эрүүгийн ялын бодлоготой уялдан, хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж нь шинэчлэгдэн, өөрчлөгдсөөр /1931, 1966, 1981, 1993, 1996, 2002/¹ ирсэн билээ. Эдгээр үе үеийн хууль, тогтоомжуудын дагуу тус байгууллага нь гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоосон этгээдийн ялыг албадан эдлүүлэх, /эрүүгийн болон иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх/ чиг үүргийг хэрэгжүүлсээр ирсэн ба үүнийг гардан хэрэгжүүлдэг хүмүүс бол ШШГБ-ын албан хаагчид юм.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, тухайлбал НҮБ-ын Ерөнхий ассамблейн баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй”² гэж, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад “Хүн бүр амьд явах салшгүй эрхтэй.

¹ А.Лхагва. Гяндан салаанаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болж өргөжсөн түүхэн замнал. - УБ.: 2001.

² НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 3 дугаар зүйл.